

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн!

АНХ ДЭГДЭЭР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

26 дахь жилдээ

№ 28 (2292)

1974 оны 4 дүгээр сарын 8

ДАВАА

БОЛОВСОН ХҮЧИНД ТАВИХ ШААРДЛАГА, ХАЛАМЖ

Мэргэжлийн боловсон хүчний тоо түргэн өсч манай ХАА-н үйлдвэрт төрөл бүрийн мэргэжилтнээр хангагдаж байгаа нь ХАА-г шинжлэх ухааны тодорхой мэдлэгтэй удирдах бололцоо олгож байна.

Нам улсын байгууллагаас мэргэжлийн боловсон хүчинтэй ажиллах ажлын далайц үр нөлөөг дээшлүүлж, түүний арга хэлбэрийг одоогийн шаардлагын хэмжээнд хүртэл сайжруулж, боловсон хүчний хариуцлагыг дээшлүүлснээр энэ бололцоо бүрэн биелж чадна.

Орон нутгийн нам, захиргааны байгууллагуудаас мэргэжилтнүүдтэй ажиллах ажиллагаа сайжирч боловсон хүчний асуудлыг хурлаараа хэлэлцэх, мэргэжилтний зөвлөл, боловсон хүчний олон нийтийн товчоо байгуулж ажиллуулах, тэдний тайланг хамт олон, хөдөлмөрчдийн өмнө тавих, нэгтгэл сонголыг авч заавар зөвлөлгөө өгөх, семинар явуулах зэрэг ажлын сайн эхлэлт гарч байна.

Гэвч мэргэжилтэй боловсон хүчний өсөлтийн дагуу тэдний эрхлэж байгаа ажлын үзүүлэлт байнга сайжирч байх ёстой атал энэ шаардлага тэр бүр хангагдаж чадахгүй байгаа нь боловсон хүчинтэй ажиллах ажиллагаа жигд биш, мэргэжилтнүүдийн хувийн хариуцлага, санаачлага сул байгааг харуулж байна. Тус аймгийн нэгдэл, САА-д, ХАА-н мэргэжилтний зөвлөл 17, боловсон хүчний олон нийтийн товчоо 10 байгуулагдсан боловч ажиллагаа нь тогтмол бус байгаагийн дээр Борнуурын САА, «Туяа», «Улаанбаатар», «Хэрлэнбаян» зэрэг нэгдэлд ХАА-н мэргэжилтний зөвлөл, товчоод байгуулагдаагүй байна. Иймд нэгдэл, САА бүр мэргэжлийн боловсон хүчинтэй ажиллах ажлыг сайжруулах талаар МАХН-ын Төв Хорооны бүгд хурлуудын шийдвэр, Улс төрийн товчооны 100 дугаар тогтоолын заалт нэг бүрт хувийн хэрэг нээж биелэлтийг гарган зохих дүгнэлт хийж ажиллах явдал чухал байна.

Мэргэжилтний зөвлөл, товчоодын ажлыг тогтмолжуулж, мэргэжилтнүүдийн тайланг хэлэлцэж, ажлын арга барилыг дээшлүүлэх, зөвлөлгөө, санамж өгөх, уулзалт, өдөрлөг, зөвлөлгөөн, онолын бага хурал зохион явуулах, мэргэжлийн тодорхой асуудлыг хамтран судлах, үйлдвэрлэл, эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, нөөц бололцоог илрүүлэн ашиглах, туршилт сорилт явуулах ажлыг өргөн зохиох нь зүйтэй.

ХАА-н салбар гол гол мэргэжилтнээр үндсэндээ хангагдаад байхад мал сувайраха, өвчнөөр хоргодох, тариа ногооны ургац тогтвортой бус байгаад тэнд ажилладаг мэргэжилтэн нар ч өөрсдөө дүгнэлт хийж тооцоо судалгаа, шинжлэх ухааны үндэслэлтэй асуудал боловсруулан төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлж ажлаа эрс сайжруулан үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх тодорхой зорилт тавьж ажиллах хэрэгтэй. Мэргэжилтэн бүр социалист уралдаанд үүрэг амлалт авч малын зүй бусын хорогдлыг зогсоох, шилмэл хэсэг суурь байгуулж үржлийн ажлыг сайжруулах зэрэг тодорхой зорилт тавьж бүтээлч ажлын төлөвлөгөөтэй ажиллах нь чухал.

Үйлдвэрлэл болон эдийн засгийн тодорхой асуудлыг мэргэжилтэн нарт шууд хариуцуулан биеийн даалгаж ажиллуулахын оронд мэргэжилтнийн шаардагдхгүй туслах чанартай аар саар ажил хийлгэж мэргэжилтний хүнийг дутуу ашиглах, тэдний санал зөвлөлгөөнд хайнга хандсанаас чухал ажил хөцрөхөд хүрдэг явдал зарим газар байгаад дүгнэлт хийж мэргэжилтний хөдөлмөрийг зөв ашиглах нь чухал байна.

Мэргэжилтэн нарыг Марксист-Ленинист улс төрийн боловсрол, мэргэжил, орос хэлний мэдлэгээ байнга дээшлүүлэн, үзэл суртлын төсвөр хатуулж, ёс суртахууны өндөр чанар эзэмшиж, мэргэжил дээрээ түргэн өсч ажлын дадлагатай болгоход нь нам, төрийн байгууллагаас байнга анхаарч халамжилж байхын зэрэгцээгээр тэдний хувийн хариуцлагыг дээшлүүлэх талаар тавих зарчмын шаардлага, хяналт шалгалтаа эрс сайжруулах хэрэгтэй.

АЙМГИЙН НАМЫН ХОРООНД

Аймгийн Намын хорооны товчооны хурлаар «Төл бойжуулах ажлын явцын тухай» Жаргалантын САА-н намын хорооны нарийн бичгийн дарга Н.Дашнямын сонголыг хэлэлцэж тодорхой заалттай протокол гаргалаа. Уг протоколд:

Тус САА өвс, хүчит ба эрдэс тэжээл бэлтгэх, бүх өрөмдөл, бетон цагирт худгуудыг ажиллагаанд оруулж гар усалгааны цэг, усан сан байгуулж төлчид, малчдад сууц 7-г шинээр барьж өгч, хоол, тулш, эмийн сан, хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангасны гадна сум, тасгийн төвөөс намын гишүүд, аварга, комбайнч тэргүүний 95 хүнийг намын байгууллагуудаас төлчнөөр томилон батлаж семинар, зөвлөдгөөнөөр хангаж ажиллуулан мал аж ахуйн мэргэжилтэн малчдын дунд болзолт уралдаан зарлан дүгнэж байна.

Гэвч малчид, төлчдийн хариуцлагыг жигд сайжруулж чадаагүйгээс төл хатгалга тусах, уураг зангирах, өлбөрөх, даргадах зэрэг шалтгаануудаар төл бойжуулж бай-

гаа суурийн 58 хувьд хорогдол гарч сумын хэмжээгээр 353 төл хорогдуулжээ. Өсвөр насны малын арчилгаа, тэжээл дутагдсанаас 221 том мал хорогдож 179 мал хээл хаясан ноцтой дутагдал байгааг тус хурал буруушааж тэмдэглэв.

Төлийн хорогдлыг бүрэн зогсоож МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлаас дэвшүүлэн тавьсан зорилтыг мал төлүүдлэх 17 суурийн 15 суурь нь биелүүлж чадна гэж Н.Дашнямын авсан амлалтыг аймгийн Намын хорооны товчоо анхааралдаа авав. Цаашид Жаргалантын САА-н намын хороонд зохиосон ажил авсан арга хэмжээний үр дүн бага байгаад дүгнэлт хийж малчид мал аж ахуйн мэргэжилтнүүдийн ажлын хариуцлагыг сайжруулан зохион байгуулалт гүйцэтгэлийн шалгалтыг нарийн хослуулахыг заав.

Мөн мал эмнэлгийн байгууллага эмчилгээ тэжээлийн цэгийн ажлыг шаардлагын хэмжээнд хүртэл сайжруулах, МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлаас төл бойжилтын талаар тавьсан

зорилтыг биелүүлэх боломжийг төлөх малын суурь, намын гишүүд бүрээр сайн тооцож нэмэлт үүрэг амлалт авахуулж МАА-н мэргэжилтэн удирдах ажилтнуудын тусалцаа үзүүлж, шалгаж байх, 6 о д малын хариулга маллагааг сайжруулж алууг манаатай болгож, үнээнд техникчийн календарийг тогтмол хөтлүүлэн зохих хугацаанд хээлтүүлэг хийж байхын чухлыг заав.

Мөн Баян-өнжүүл суманд байгалийн гэнэтийн аюулаас сэргийлэн хамгаалах нөмөр халхавч төлийн тэжээлгүйгээр төл бойжуулж байгаа байдал, Баянзүрх, Сэргэлэн, Алтанбулаг зэрэг сумдад хөрвөжсөн төлийг эхийн дагуулан бэлчээж сэнсрүүлэн төл хорогдуулж байгаа, Бүрэн суманд төлийн тооллогыг суурь нэг бүрт биечлэн хийгээгүйгээс ихэр төлийн ба төлийн хорогдол тооцоо байхгүй төл бойжилтын мэдээг буруу өгч байгаа зэрэг дутагдлыг нэн даруй засахыг САА, ХАА-н нэгдлийн намын байгууллагуудад даалгасан байна.

БҮХ НИЙТИЙН ХҮЧ АНХААРЛЫГ ТӨВЛӨРҮҮЛБЭ

Энэ 4 дүгээр сарын 3-ны өдөр аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны гишүүдийн хурал болж төл бойжуулах ажлыг хэрхэн зохион байгуулж байгаа тухай Заамар сумын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга Д.Мишигдоржийн илтгэл, малын зүй бус хорогдлыг багасгах талаар зохиож байгаа ажлын тухай Лүн сумын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга Х.Самдангийн илтгэлийг тус тус авч хэлэлцэв.

Хуралд тавьсан илтгэл, үг хэлсэн хүмүүсийн санал дүгнэлтээс үзэхэд эдгээр сумдын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, МАХН-ын Төв Хорооны VII бүгд хурлын шийдвэр ялангуяа малын зүй бус хорогдлыг багасгах, төл бойжуулах талаар наамаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үзэл суртал зохион байгуулалтын нилээд арга хэмжээ авчээ.

Заамар сумын АДХ-ын гүйцэтгэх захиргаа мал төлүүлэх сууриудын

дунд төлийн 4 штаб байгуулан ажиллуулж, усны групп гарган худаг засварлуулах ажил зохиож төлөх малын сууриудыг тэжээл, байр зэрэг материаллаг баазаар сайн хангасан байна. Мал төлөхийн өмнө сумын төлчин эмэгтэйчүүдийн зөвлөдгөөн хийлгэн, малчид, төлчдөөр социалист уралдаанд үүрэг авахуулан уралдааныг 10 хоног тутам дүгнэж байгаагийн дээр нэгдлийн зөвлөдгөөс нийт малчидтай төл бойжилт толой хамгаалалтаар гэрээ хийж ажилласны үрээр 61 суурьт төлийн хорогдолгүй, төл бойжилт 98 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төлийн хорогдол 2 гаруй дахин бага байна.

Гэвч тус сум одоогийн байдлаар 295 төлийг арчилгаа, маллагааны муугаас хорогдуулаад байгаа нь аймгийн хэмжээгээр хорогдсон төлийн 18 хувийг эзэлж байна. Төл олноор хорогдсоны шалтгаан нь цагийн сайханд тайвширч төлийн

бэлтгэлийг бүрэн сайн хийгээгүй, малчдын хариуцлага сул, бүх нийтийн хүч анхаарлыг төл бойжуулалтад төвлөрүүлэн чиглүүлж, хяналт шалгалтыг сайжруулж чадаагүй явдал мөн гэж уг хурал үзэв. Түүнчлэн малчин Дамбажаа 36 хурга осгоож, Гочоо, Мөнхбаяр нар 20-42 төл харангадуулж үхүүлсэн байна.

Алтай үүлдрийн төлийн байрны дулаалгыг тохируулж чадаагүй, хэвтэр хүйтэн, бууц хүрэлцээ муутай, пүнзэнд наар хийх дэвшилтэт аргыг хэрэглээгүй зэргээс эрлийс төл олон тоогоор хатгалга тусч, хорогдол үргэлжилж байна.

Тус суманд ботгыг уях нэмнэх ажил хийгдээгүйн дээр адууг азарга азаргаар төлүүлэх бэлтгэл хангагдаагүй, төл мал тэжээх жор хэмжээг нарийн баримтлахгүй байгаа дутагдал илэрчээ.

Эдгээр дутагдалд дүгнэлт хийж, төл бойжуулах малын зүй бус

(Төгсгөл нь II нүүрт)

Аймгийн улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 1974 оны 1 дүгээр улирлын төлөвлөгөөний биелэлтийн дүнгийн тухай Статистикийн товчооны мэдээлэл

Аймгийн хэмжээгээр төлөвлөх зохиох эх малын 45,7 хувь нь төлөж, 295,5 мянган төл бойжиж, бойжилт нь 99,3 хувьтай байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал төл бойжилт 35,6 хувиар дээгүүр, ХАА-н техник засварлалт 88,9—97,1 хувьтай байгаа нь өнгөрсөн оныхоос 1,2—10,0 хувиар нлүү байна.

Үйлдвэрүүдийн нийт бүтээгдэхүүний төлөвлөгөөний биелэлт, өсөлтийг үзүүлбэл; (хувиар)

	төлөвлөгөөний биелэлт	1973 оны мөн үетэй харьцуулбал
Хүнсний комбинат	119,0	86,6
Сонины үйлдвэр	107,4	93,9
НААҮ-ний газар	108,5	112,4
Ойн аж ахуй		
модны үйлдвэр	110,1	84,5
Баянчандманий засварын газар	42,9	49,8
Архустын тэжээлийн үйлдвэр	79,2	199,4
Эрдэнэсантын	65,2	119,5
Баянцогтын	80,9	3,8 да
Угтаалын	46,5	162,1

Хүнсний комбинат архи, НААҮ-ний газар гутал, төмөр эдлэл, Сонины үйлдвэр сонин, ном товхимол үйлдвэрлэх төлөвлөгөөг тус тус тасалдуулжээ. Барилга угсралтын төлөвлөгөөг 93,1 хувиар биелүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 16,1 хувиар багасчээ.

Барилга угсралтын ажлын төлөвлөгөөний биелэлт, өсөлтийг үзүүлбэл; (хувиар)

	төлөвлөгөөний биелэлт	1973 оны мөн үетэй харьцуулбал
Барилга угсралтын контор	110,9	128,4
УАА-н барилга угсралтын контор	6,1	3,3
Зам анги	2,3 да	2,2 да

Жижиглэн худалдаалах бараа гүйлгээний төлөвлөгөөний биелэлт, өсөлтийг байгууллагуудаар үзүүлбэл; (хувиар)

	төлөвлөгөөний биелэлт	1973 оны мөн үетэй харьцуулбал
ХБУ газар	100,0	99,6
Соёлын хэлтсийн номын худалдаа	114,2	104,7
Эмийн сангийн гүйлгээ	102,0	91,0
Хэвлэлийн гүйлгээ	100,7	103,4

Бэлтгэлийн 38 нэр төрлийн зүйлээс 11 нь 100 ба түүнээс дээш хувиар биелэгдээд байна.

Соёлын байгууллагуудын орлогын төлөвлөгөө 119,0 хувиар биелэгдэж, Эрүүлийг хамгаалах байгууллага амбулаторын үзлэг, урьдчилан сэргийлэх тарилга, ясли, эмнэлгийн ор хоногийн төлөвлөгөөг 68,9—98,6 хувиар биелүүлсэн нь урьд оноос 2,6—14,4 хувиар доогуур байна.

Ахуйн болон нийтийн аж ахуйн үйлчилгээний орлогын төлөвлөгөөний биелэлтийг үзүүлбэл;

	төлөвлөгөөний биелэлт	1973 оны мөн үетэй харьцуулбал
Зочид буудал	108,0	98,1
Халуун ус	74,3	63,5
Угаалга	100,0	70,2
Үсчин	100,0	102,0
Оёдол (захилга)	120,0	129,0
Гутал засвар	75,4	148,6

НААҮГ нь зочид буудлаар 5,7 мянган ор хоног, халуун ус, үсээр 17,0 мянган хүнд үйлчилж бүх үйлчилгээний орлогын төлөвлөгөөг 111,3 хувиар биелүүллээ.

СТАТИСТИКИЙН ТОВЧОО

БҮХ НИЙТИЙН ХҮЧ АНХААРЛЫГ ТӨВЛӨРҮҮЛБЭ

Төгсгөл. (Түрүүч нь
I нүүрт)

хорогдлыг багасгах талаар Ю. Цэдэнбал даргын даалгаврыг яв цав хэрэгжүүлж төлийн хорогдлыг эрс шийдвэртэй таслан зогсоохыг нөхөр Мишигдоржид даалгав.

Мөн төл бойжуулах хөрвийн арга, мал маллаганы технологи-шинэ арга барилыг нэвтрүүлэн, малын эмч, хариуцлагатны хариуцлагыг өндөржүүлэх нь чухал гэж үзэв.

Лүн сумын АДХ-ын гүйцэтгэх захиргаа малын зүй бус хорогдлыг багасгах талаар тодорхой арга хэмжээ авч сумын захиргааны гишүүдийг бригад даалган өгч ажиллаж байгаа болон суурь бүрт толгой хамгаалалтын онцгой даалгавар гардуулжээ. Усан хангамжийг сайжруулах арга хэмжээ авсны үрээр нийт суурийг усны савтай болгож ус зөөвөрлөх машин, трактор гарган ажиллуулж байна.

Тэжээл эмчилгээний цэгийн тоог олшруулан аж ахуй зохион байгуулалтын талаар бэхжүүлж 2340 гаруй малыг цугларуулан үйлчилж байгаа нь үрдүн өгчээ. Төл бойжуулалт тус суманд 99,8 хувьтай байна.

Гэвч одоогийн байдлаар 704 мал хорогдоод байгаа нь хорогдлын хэмжээ урьд оны мөн үеийнхээс 40 хувиар өссөн байна.

Энэ нь зохиосон ажил үр дүн багатай байгааг харуулсан баримт юм. Тэжээл эмчилгээний за-

рим цэгийн ажил сайнгүйгээс өвчилсөн малын эдгээрт харьцангуй бага байгаа бөгөөд эргүү өвчний улмаас тураалд хүрэх, үхэх явдал хорогдлын нилээд суурийг эзэлж байна. Сумын гүү, үнээний 21-14,3 хувь нь сувайрсны гадна адуун сүргийн дотор эзлэх эх малын хувийн жин үлэмж бага болсон зэрэг нь яаралтай арга хэмжээ авахгүй бол мал өсгөх зүй бус хорогдлыг багасгахад муугаар нөлөөлж болзошгүй байна.

Тус суманд малын эмч, зоо-техникчдийн ажлын хариуцлага сулаас мал эмчилгээний үр дүн сайнгүй, ялангуяа тэднээс малчдад мал тэжээх аргыг олигтой зааварладаггүй, эмч нарын онош тодорхой бус байгааг аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны гишүүдийн хурал буруушаан тэмдэглэв.

Лүн сумын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, мэргэжилтэн, сэхээтний хариуцлагыг өндөржүүлэх, малын зүй бус хорогдолтой тэмцэхэд төрийн байгууллагаас удирдах удирдлагын хэмжээ шаардлагат хүрээгүй, гүйцэтгэлийн хяналт шалгалт хангалтгүй байгаа зэргээс ийнхүү малын хорогдол ихэссэнийг нөхөр Самданд анхааруулав.

Тус хурлаас төрийн байгууллагын рол, удирдлагын аргыг өндөржүүлэн, төл бойжуулах, малын зүй бус хорогдлыг багасгах ажлын үр дүнг сайжруулахтай холбогдсон чухал заалт бүхий тогтоол гаргав.

УЛС ТӨРИЙН СУРГУУЛИЙН ШАЛГАЛТ ОЙРТОО

МАХН-ын гишүүд, идэвхтнийг улс төрийн сургуульд бүрэн оролцуулж сонсогчдоод Марксист-Ленинист онолыг практик амьдралтай гүнзгий холбож ойлгуулах, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх зорилтыг нам дөвшүүлсэн билээ.

Иймээс намын байгууллага, сургал нэвтрүүлэгч, сонсогч бүр улс төрийн сургуулийн талаар хариуцах хариуцлага, үйл ажиллагаандаа дүгнэлт хийж удахгүй болох шалгалтанд амжилттай бэлтгэх явдал чухал зорилт болж байна.

Шалгалтын дүн нь жилийн турш явагдсан хичээлийн чанараас шалтгаалах боловч шалгалтын өмнөх хугацаанд бүх талаар эрчимтэй бэлтгэл хийх нь бүх үзсэн зүйлээ төвлөрүүлэн ойлгож амжилттай дүн үзүүлэх асар их ач холбогдолтой нь практикт нотлогдсон зүйл юм.

Улс төрийн сургуулийн шалгалт нь намын гишүүд, идэвхтнийг онол улс төр,

ажил төрлийн мэдлэг, ойлгоцог дүгнэх хэмжүүр төдийгүй тэднийг анги дэвшүүлэх гол үндэслэл намын даалгаварт хир зэрэг зарчимтай хандаж биелүүлдэг ухамсар, хариуцлага, сахилга батын шалгуур болгийн хувьд шалгалтыг сайн бэлтгэж чанартай, үзэл суртлын өндөр хэмжээнд явуулах нь чухал байна.

Улс төрийн сургуулийн шалгалт нь зөвхөн онолын мэдлэгийг бус сонсогчдын хичээлд оролцсон байдал идэвхийг нэгэн адил үзэж үнэлэх ёстойг сонсогчдоод сайтар ойлгуулсан байх ёстой.

Ийм учраас шалгалтанд бэлтгэхэд суртал нэвтрүүлэгчдийн үүрэг, хариуцлага их юм.

Юуны урьд сонсогчдыг шалгалтанд бэлтгүүлэх хугацаанд суртал нэвтрүүлэгч хүн бүртэй тодорхой ажиллаж онолыг эзэмшүүлэх олон хэлбэр, зүйл ажлыг санаачлан зохиох ёстой.

Намын байгууллагууд улс төрийн сургуулийн

шалгалтын бэлтгэлтэй холбогдуулж товчооны гишүүдийн үзлэг хийх, суртал нэвтрүүлэгч зарим сонсогчдын сонсогчдыг хэлэлцэх, сонсогчдоод хэлсэгчилсэн зөвлөлтөө өгөх нь зүйтэй.

Намын бодлогын цаг үеийн асуудал, тогтоол шийдвэр, төлөвлөгөөт зорилтын биелэлт, үйлдвэрлэлийн явцын талаар гарын авлага бэлтгэж өгөх, сонсогч хийх, шалгалтанд бие даан бэлтгэж байгаа байдал, давтлага консултанцын чанарыг шалган зөвлөлтөө өгч түүнийг биелэлтэд хяналт тавьж ажиллавал зохино.

Өнгөрсөн оны хичээлийн эцэст улс төрийн сургууль онолын семинарын сонсогч 1373 хүн шалгалтанд орж 100 хувийн сурлагын дүн үзүүлсний 57,8 хувь нь онцсайн, сайн үнэлэлт авсан нь урьд жилүүдээс сурлагын чанар эрс ахисан үзүүлэлт байв. Энэ ахиц бол жилийн эцсийн шалгалтанд сум, хот, хороодын намын байгууллага, суртал

нэвтрүүлэгчид жигд сайн анхаарч сонсогчдын бэлтгэлийг хангуулсны үр дүн мөн.

Шалгалтанд Баянчандмань, Баянцогт, Борнуур, Эрдэнэ сумын намын байгууллага бусдаас давуутай бэлтгүүлж сонсогч, суртал нэвтрүүлэгчдэд сайн тусалсны дүнд сонсогчдын 60—70 хувийг онцсайн, сайн дүнтэй сурлагын авчирч байгаа нь онцгой амжилт мөн. Баянцогтын намын хороо «Сонсогчдоод тусламж» бичлээл сэтгүүлийн цувралаар САА-н төлөвлөгөөт зорилт, орчин үеийн асуудлаар чухал сэдвүүд гаргаж өгсөн нь шалгалтын бэлтгэлд чухал зүйл боллоо гэж сонсогчид үнэлж байна.

Зуунмод хотын намын хороо заах аргын зөвлөлтэй хамтран суртал нэвтрүүлэгчид, заах аргын зөвлөлийн гишүүдээр олон улсын байдлаар цуврал мэдээлэл, эх зохиолын товчлол бэлтгүүлэн зөвлөлтөө өгүүлэх, тусгай лекц хийлгэх, гарын авлага гаргах ажил зохиосон байна. Гэвч Дэлгэрхаан, Лүн

зэрэг зарим сумдын намын байгууллага улс төрийн сургуулийн сонсогч, суртал нэвтрүүлэгчдийг жилийн эцсийн шалгалтанд бэлтгүүлэх ажлыг хангалтгүй зохион байгуулсан нөхцөлд дутагдал оршиж байлаа.

Өмнөх жилүүдэд оршиж байсан дутагдалд дүгнэлт хийж 1972—1973 оны сурлагын амжилтыг улам ахиулах, ялангуяа тодорхой шалтгааны улмаас удаан хугацаагаар хичээлд суугаагүй сонсогчдоод туслан шалгалтанд бэлтгүүлэх ажлыг онцгой анхаарах хэрэгтэй.

Намын улс төрийн сургуулийн хичээлийн жилийн дүнг намын хурал, сонсогчдын зөвлөлтөөнөөр хэлэлцэж, сонсогч бүрийн улс төр, онолын мэдлэгийн өсөлтийг хичээлд оролцсон оролцоо, эрхэлсэн албан үүрэгт ажил, үйлдвэрлэлийн төлөвлөгөө, уралдаанд авсан үүргийн биелэлт, олон нийтийн ажилд оролцсон байдалтай холбон дүгнэж, суртал нэвтрүүлэгчдийн ажилд үнэлэлт өгвөл зохино.

Ч. ЖАНЧИВДОРЖ

Улс төрийн сургуулийн сонгогчдод тусламж

В. И. Ленин энэ сэдвийг 1920 оны 6 дугаар сард коммунист интернационалын II их хуралд зориулан санал авах зорилгоор бичсэн бөгөөд 1920 оны 7, 8 дугаар саруудад хуралдсан коммунист интернационалын II их хурал энэхүү сэдвийг их хурлын тогтоол болгон баталсан юм.

Аугаа их октябрийн чөлөөлөгч үзэл санаагаар зоригжсон Ази, Африкийн улс орнууд империалист колончлолын эсрэг, үндэсний тусгаар тогтнолоо олохын төлөө тэмцэлд босч байсан үедэнэ Чухал асуудлын талаар коммунист намуудын баримтлах чиг бодлогыг боловсруулах асуудал коммунистийн II их хурлын өмнө тавигдсан билээ.

Энэхүү чиг бодлогын үндсэн зарчмыг Ленин 12 зүйлээс бүрдсэн энэ сэдвээр маш цэгцтэй тодорхойлсон юм.

Ленин, хөрөнгөтний ардчилал гэгчийн мөн чанарыг зааж, хөрөнгөтний ардчилал бол ерөөсөө тэгш байдлын тухай, түүний дотор үндэсний тэгш байдлын асуудлыг хийсвэр, ёс болгон тавьж хүмүүс адил тэгш гэдэг нэрийдлээр мөлжигч, мөлжигдөгч хоёрыг „тэгш“ гэж тунхаглаж, үүгээрээ дарлагдсан ангийг мэхлэж ангиудыг устгах явдлыг эсэргүүцэн тэмцэх зэвсэг болгодог бөгөөд харин „тэгш“ болгох гэсэн жинхэнэ утга учир нь ангиудыг устгах гэсэн шаардлагат л оршино гэжээ.

Иймээс коммунист намууд хөрөнгөтний хуурамч ардчилалыг илчлэн түүхэн тодорхой эдийн засгийн нөхцөл байдал, мөлжигдсэн хөдөлмөрчин анги, дарлагдсан хараат, тэгш эрхгүй үндэстнийг эрс зааглан үзэхийг онцлон заасан юм.

Ленин капитализмын эсрэг хувьсгалт тэмцэлийнхний тулд пролетари нар болон хөдөлмөрчин олон түмнийг ойртуулах явдал чухалчлан заасан нь орчин үед үлэмж ач холбогдолтой юм.

Янз бүрийн үндэстний хөдөлмөрчдийг ойртуулахын тул колон орнуудын эрх чөлөөний бүх хөдөл-

амьдралтай болгож болохгүй гэж заасан юм.

Ленин энэ холбооны бүрэн төгс нэгдэх ирээдүйн ач холбогдлыг өндөрөөр үнэлж нийт үндэстний пролетари нараас ерөнхий төлөвлөгөөгөөр жолоодох, бүх дэлхийн бүхэл бүтэн нэгдмэл аж ахуй бий болгох хандлага байгаа бөгөөд тийм хандлага капитализмын үед бүрэн илэрсэн нь цаашдаа социализмын үед улам хөгжин бүрэн төгс дуусах юм гэж суутгар урьдчилан харсан нь орчин үед социалист орнуудын хамтын ажиллагаа социалист интеграцийн үйл ажиллагаагаар хэрэгжин биелэгдсээр байна.

В. И. Лениний „Үндэсний ба колонийн асуудлын талаар гаргах сэдвийн анхны ноорогийн“ тухай

гөөнийг Зөвлөлт орос улстай маш нигт холбоотой болгох, коммунист хөдөлгөөнийг хоцрогдсон орон, үндэстний доторхи ардчилсан эрх чөлөөний хөдөлгөөнтэй холбох холбооны хэлбэрийг тодорхойлж, нийлэмжтэй болохоо ажил хэрэг дээр харуулсан Зөвлөлт бүгд найрамдах холбоот улсуудын холбоог улам нигтрүүлэх чухлыг онцлон тэмдэглэж үүнийг үйгээр Зөвлөлт бүгд найрамдах улсуудын оршин тогтнох явдлыг сахин хамгаалах, хөдөлмөрчдийг сайхан аж

Капиталист орны дотор үндэсний цөөнхийн эрхийг ямагт зөрчиж байдаг бөгөөд гагцхүү Зөвлөлт засаг л үндэстнийг жинхэнэ тэгш эрхтэй болгож чадахыг байнга тайлбарлах, үндэстний болон колонийн хувьсгалт хөдөлгөөнд нийт коммунист намууд шууд туслах хэрэгтэй гэж Ленин заажээ.

Ленин пролетарийн интернационализмыг аман дээрээ зөвшөөрчихөөд, биелүүлэх ажил хэрэг дээрээ болохоор түүнийг үндэсний жижиг хөрөнгөтний амна бодох бэртэгчин

үзлээр солих явдалтай шийдвэртэй тэмцэхийг зааж пролетарийн интернационализмын зарчмыг тодорхойлохдоо: «Нэгдүгээрт нэг орны пролетари нарын тэмцлийн эрх ашгийг дэлхий дахины хэмжээний энэ тэмцлийн эрх ашигт зохицуулах, хоёрдугаарт хөрөнгөтнийг ялж байгаа үндэстний зүгээс дэлхий дахины капиталыг унагаахын тулд улс үндэсний үлэмж их хэлмэгдэл хүлээх чаддалтай бөгөөд бэлэн байхыг шаардаж байгаа юм» гэжээ.

Уг сэдэвт баруун европын пролетари нарыг колони, хоцрогдсон орнуудын тариачны хөдөлгөөнтэй аль болох нягт холбож, түүнийг үлэмж их хувьсгалт чанартай болгох, капитализмын өмнөх харилцаа ноёрхож байгаа орнуудад «Хөдөлмөрчдийн зөвлөл» байгуулах явдлын чухлыг онцлон заасан байна.

Хоцрогдсон улс орнуудад газар тариалангийн жижиг үйлдвэрлэл, эцэг өвгийн үеийн бүдүүлэг, бөглүү байдал, жижиг хөрөнгөтний мухар, үндэсний хар амна бодох үзэл, үндэсний явцуу заншил ихээхэн байдаг тул үүнд туйлын болгоомжтой, анхааралтай хандах нь чухал болохыг зааж байв.

В. И. Лениний энэ сэдэв одоогоос 50 гаруй жилийн өмнө бичигдсэн боловч орчин үед коммунист ажилчны намуудаас үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний талаар баримтлах чиг бодлогын үндэс болсоор байна.

Я. ДАМДИНСҮРЭН

Шефтээ туслав

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Барилга архитектурын комиссын Улсын барилгын зургийн төв институтын нам, захиргаа, олон нийтийн байгууллага, өөрийн байгууллагын шеф Өндөрширээт сумын «Хөгжил» нэгдэлд 1973—1974 онд туслах төлөвлөгөө гарган амжилттай ажиллаж байна.

Малын тэжээл татахад 4 машин, 8 хүн, төл хүлээн авах ажилд 13 хүнийг 2—3 сарын хугацаатай ажилдуулж, бод бог малын нэмнээ, хурганы уут 1217 ширхэгийг бэлтгэх хүргүүлэв.

Шефийн нэрэмжит социалист уралдаан зарлан дүгнэж, тэргүүний малчдад 10000 төгрөгний шагналыг олгов.

Мөн тэжээл эмчилгээний цэгийн тохилгог барилгыг өөрийн хүч хөрөнгөөр барьж ашигдалтанд оруулжээ.

Мөн МАХН-ын Төв Хорооны бүгд хурлуудын шийдвэрийг сурталчлах, ухуулгын бригадыг Зудад гарган, давхардсан тоогоор 3000 орчим хүнд үйлчилж лекц яриа үздэшлэг уулзалт зохиов.

Ийнхүү Улсын барилгын зургийн төв институтын хамт олон шеф сум-нэгдэлдээ сайхан тусалцаа үзүүлж нэгдэлч олны талархлыг зүй ёсоор татаж байна.

Х. ОРОСОО

АХМАД СААЛЬЧИН

Аймгийн 4 удаагийн аварга саальчин Хорлоо 10 гаруй жил саальчнаар ажиллаж сарлагийн үхрийн арчилгаа маллагааг тохируулах талаар туршлагажээ.


Тэрээр төллөх дөхсөн үнээг ойрын бэлчээрт хариулан ус тэжээлээр сайтар хангаж, ажиллагаас төлөө бүрэн бойжуулж малын ашиг шимийг бүрэн ашиглаж байна.

Нас өндөр болсон боловч нэгдэл нийгэмдээ ихийг бүтээх эрмэлзлэл бүхий энэ ахмад саальчин сүүлийн 3 жилд тушаах сүүнийхээ төлөвлөгөөг 144—221 хувиар биелүүлжээ.

Саальчин Хорлоо V таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жилд 5 жилийн төлөвлөгөөт сүүгээ 111 хувиар биелүүлж 2811 литр сүүгээр давуулжээ.

Ингэж 5 жилийн ажлыг 3 жилд багтаан хийж хариуцсан малынхаа хөөвөр хялгасны төлөвлөгөөг жил дараалан 100,9—111 хувиар биелүүлсэн энэ хүн бол Баянзүрх сум нэгдлийн саальчин юм.

Л. СОДНОМДАРЖАА



Монголморет сумын „Улаанбаатар“ нэгдлийн „Байдал“ бригадын үхэрчин Д. Галсан олон жил бэлтгэлийн насны үхэр хариуцан маллаж тарга хүч сайтай улсын бэлтгэлд тушаадаг юм. Зураг дээр: Үхэрчин Д. Галсан үхрээ хариулж байгаа нь.

Л. ГУНГААБУУ-гийн авсан гэрэл зураг

Амжилт илтгэсэн мөрүүд

Баяндэлгэр сумын НААУ-ний ангийн оёдолчин МХЗЭ-ийн гишүүн Т. Долгорсүрэн ахлагчтай залуучуудын нэрэмжит хөдөлмөрийн гавиштай бригадын хамт олон 1973 оныхоо төлөвлөгөөг 139 хувь биелүүлж хөдөлмөрийн сайхан амжилт гаргасан юм.

Одоо тус бригадын залуу ажилчид бүх ард түмний уралдааны жил—1974 онд 388,6 мянган төгрөг-

ийн бүтээгдэхүүн гаргах төлөвлөгөөг давуулан биелүүлж нөөц бололцоог ашиглах замаар 3800 гаруй төгрөгийн хуримтлал оруулахаар шамдан ажиллаж байна.

Эдний бригадынхан үйлдвэрийн жигд ажиллагааг хангасны дүнд оны эхний 1, 2 дугаар сарын төлөвлөгөөг 103,2—105 хувь биелүүлжээ.

Эрдэнэ сумын 8 жилийн дунд сургуулийн

захираанаас «Пионерийн үнэн» сонины 30 жилийн ойн нэрэмжит кросс уралдаан явуулав.

Энэ уралдаанд 200 гаруй сурагч хамрагдан оролцсоны дотор дунд ангиудын эрэгтэйчүүдийн уралдаанд 8-ын «А» ангийн сурагч Ю. Төмөрхуяг, эмэгтэйчүүдийн уралдаанд 7-гийн «А» ангийн сурагч Оюунцэцэг, бага ангудаас эрэгтэйчүүдээс 3-ын «А» ангийн сурагч Батсайхан, эмэгтэйчүүдээс мөн ан-

гийн сурагч Энхтүяа нар түрүүлж сургуулийн аварга болов.

Ц. ГОМБО

Баяндэлгэр сумын «Хэрлэн баян» нэгдлийн саальчин илгээлтний эзэн П. Жаргал өнгөргөч оны сүүний төлөвлөгөөг 1250 литрээр давуулсан амжилтаа улам бататгахаар чармайж байна.

Энэ саальчин 1974 оны эхний улирлын төлөвлөгөөг олон литр сүүгээр давуулаад байна.

Н. БАЯРАА